



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
НИЙТ ШҮҮГЧИЙН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ

2026 оны 01 сарын 09 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Их нам (ИХН)-ын Үндсэн
дүрэм (шинэчилсэн найруулга)-ийг
бүртгэх тухай

Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааныг Ерөнхий шүүгч Д.Ганзориг даргалж, Танхимын тэргүүн Д.Мөнхтуяа, Ч.Хосбаяр, шүүгч Б.Амарбаясгалан, Д.Батбаатар, Б.Батцэрэн, Г.Банзрагч, Н.Батчимэг, Н.Батзориг, Э.Золзаяа, Ц.Оч, М.Пүрэвсүрэн, П.Соёл-Эрдэнэ, С.Соёмбо-Эрдэнэ, Б.Ундрах, Б.Цогт, Ц.Цогт, Д.Цолмон, Х.Эрдэнэсүвд нарын бүрэлдэхүүнтэй хийсэн хуралдаанаар,

Их нам (ИХН)-ын Үндсэн дүрэм (шинэчилсэн найруулга)-ийг бүртгүүлэх тухай өргөдлийг шүүгч Ц.Цогтын танилцуулснаар хэлэлцээд

ТОДОРХОЙЛОХ нь:

Их нам (ИХН)-ын дарга Ө.Баяраагаас “Их намын Үндсэн дүрмийн шинэчилсэн найруулгыг бүртгүүлэх” өргөдлийг 114 хуудас баримт, 1 ширхэг флашны хамт 2025 оны 12 дугаар сарын 12-ны өдөр Улсын дээд шүүхэд ирүүлжээ.

Дээрх өргөдөл, хавсралтаар ирүүлсэн баримтуудыг Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга) болон Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 06 дугаар тогтоолоор баталсан “Улс төрийн намын бүртгэл хөтлөх журам”-ын 2.5-д заасны дагуу Их чуулганы төлөөлөгчдөд хурлын тов хүргэсэн, хуралд оролцсон төлөөлөгчдийг намын гишүүн мөн эсэхийг нотолсон баримтыг тус тус ирүүлэхийг мэдэгдэхэд 2025 оны 12 дугаар сарын 24-ний өдөр Их намын ээлжит бус Иргэний Их чуулганы хуралдааны товыг мэдэгдсэн тэмдэглэл, намын гишүүний үнэмлэх, төлөөлөгчдийн бүртгэл зэрэг 45 хуудас баримтыг ирүүлсэн.

Мөн Үндсэн дүрэм (шинэчилсэн найруулга)-ийн зарим заалтыг тодруулахаар 2025 оны 12 дугаар сарын 26-ны өдөр сонсох ажиллагаа явуулсан бөгөөд нэмэлтээр ирүүлсэн намын даргын тайлбарыг шалгаад дээрх журмын 6.6-д зааснаар нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцүүлэв.

ҮНДЭСЛЭХ нь:

Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаас Их нам (ИХН)-ын Үндсэн дүрэм (шинэчилсэн найруулга)-ийг дараах үндэслэлээр бүртгэж шийдвэрлэлээ.

Улс төрийн намын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2-т “Намын удирдах дээд байгууллага дараах асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж

шийдвэрлэнэ.” гээд 17.2.1-д “намын дүрэм, хөтөлбөрийг батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах” гэж заасны дагуу Их нам (ИХН)-ын удирдах дээд байгууллага болох намын ээлжит бус Иргэний Их чуулганаар Үндсэн дүрэм (шинэчилсэн найруулга)-ийг баталсан үйл ажиллагаа нь хуулийн дээрх зохицуулалт болон Улсын дээд шүүхэд бүртгэлтэй тухайн намын Үндсэн дүрэмд нийцсэн байна.

Нэг.Намын удирдах дээд байгууллагыг зарлан хуралдуулсан үйл ажиллагааны талаар:

Их нам (ИХН)-ын дүрмийн Гуравдугаар бүлгийн 1 дүгээр зүйлийн 1.5-д “... эсвэл намын Улс төрийн зөвлөлийн олонхын саналаар ээлжит бус Иргэний Их чуулганыг зарлан хуралдуулж болно”, 8 дугаар зүйлийн 8.3-т “Улс төрийн зөвлөлд дарга, дэд дарга нар болон Ерөнхий нарийн бичгийн дарга ажил үүргийнхээ хувьд шууд орно. Бусад гишүүдийг Иргэний Бага чуулганаас 4 жилийн хугацаагаар сонгоно ...”, 8.4-т “Улс төрийн зөвлөл нь нийт 33 хүртэл гишүүнтэй байна”, 8.7-д “Улс төрийн зөвлөлийн хуралдаанд гишүүдийн олонх нь оролцсон бол хүчинтэйд тооцно” гэж тус тус заажээ.

Өргөдөлд хавсарган ирүүлсэн Их нам (ИХН)-ын гүйцэтгэх төв байгууллага болох Улс төрийн зөвлөлийн 2025 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 06 дугаар тогтоолын 1 дэх заалтаар намын ээлжит бус Иргэний Их чуулганыг 2025 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр хуралдуулахаар, 2 дахь заалтаар “Ээлжит бус Иргэний Их чуулганы төлөөлөгчдийг сонгох журам”-ыг баталсан, тус журмаар хуралдаанд оролцох төлөөлөгчдийн тоог 250-аас доошгүй байхаар тогтоожээ. Уг тогтоолд Улс төрийн зөвлөлийн 8 гишүүн, намын дарга, Ерөнхий нарийн бичгийн дарга, 4 дэд дарга, нийт 14 гишүүн гарын үсэг зурсан нь гишүүдийн олонх болох ба эдгээр гишүүдийг намын Иргэний Бага чуулганы 2023 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 09, 11 дүгээр тогтоолоор сонгож, баталсан Улс төрийн зөвлөлийн гишүүдийн нэрстэй тулган үзэхэд ямар нэгэн зөрчилгүй байна.

Түүнчлэн, Их нам (ИХН)-ын 2025 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн ээлжит бус Иргэний Их чуулганы товыг 279 намын гишүүдэд утсаар мэдэгдсэн, үүнээс 262 төлөөлөгч хуралд оролцохоор мандат авснаас 239 төлөөлөгч буюу 91.2 хувь нь оролцсон, эдгээрийн 96 нь орон нутгийн төлөөлөл болох нь ирцийн бүртгэл, намын гишүүдтэй утсаар ярьсан тэмдэглэл, төлөөлөгчдийн бүртгэл, гишүүний үнэмлэх, хуралдааны явцыг баримтжуулсан фото зураг зэрэг баримтуудаар тогтоогдож байна.

Хоёр.Намын Үндсэн дүрэм (шинэчлэн найруулга)-ийг баталсан тухайд:

2.1.Их нам (ИХН)-ын Үндсэн дүрэм (шинэчилсэн найруулга)-ийн зарим зүйл, заалтын талаар сонсох ажиллагааны явцад тодруулахад тус намын даргын 2026 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 001/26 дугаартай албан бичгээр дараах тайлбарыг ирүүлсэн. Үүнд:

а/Үндсэн дүрмийн 15.5-д “Их чуулган намын бодлогын ямар ч асуудлыг хэлэлцэж болох бөгөөд дараах асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ.”, 5.5.9-д “Бага чуулганд, Улс төрийн зөвлөлд тодорхой асуудлаар эрх олгох;” гэж заасан нь Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийн 17.2-т заасан Удирдах дээд байгууллагын онцгой бүрэн эрхийг төлөөллийн төв

байгууллага болох Бага чуулган, гүйцэтгэх төв байгууллага болох Улс төрийн зөвлөлд олгох эсэхийг тодруулахад,

“Улс төрийн намын тухай хууль, намын дүрэмд заасан Их чуулган нь өөрийн онцгой бүрэн эрхийг шилжүүлэх тухай ойлголт биш бөгөөд ... тухайн цаг үеийн нөхцөл байдал, хэрэгцээ шаардлагаас урган гарч болох үйл ажиллагааг хэрэгжүүлэх эрх, үүргийг олгох тухай, ... Их чуулганаас шийдвэр гаргасан нөхцөлд түүнийг үйл хэрэг болгож, нарийвчлан төлөвлөж зохион байгуулах эрх, үүргийг Бага чуулганд болон Улс төрийн зөвлөлд эрх, үүрэг, даалгавар өгөх замаар шийдвэрлэж болох агуулгыг тусгах зорилгоор ийнхүү 15.5.9 дэх заалтыг оруулсан” гэж;

б/Үндсэн дүрмийн 28.7-д “Намын хяналтын байгууллагын гишүүнээр дараах этгээдийг сонгохыг хориглоно:”, 28.7.3-т “сум дүүргийн намын хорооны гишүүн, тэргүүлэгч гишүүн;” гэж заасан боловч 28.4-т “Аймаг, нийслэлийн Хяналтын зөвлөлийг аймаг, нийслэлийн Бага хурлаас 4 жилийн хугацаатай, сондгой тоотой 3-5 гишүүнтэй сонгож байгуулна. Хяналтын зөвлөлийн даргыг гишүүд дотроосоо сонгоно ...”, 28.5-д “Сум, дүүргийн Хяналтын хороог сум, дүүргийн Бүх гишүүдийн хурлаас 4 жилийн хугацаатай 3 гишүүнтэй сонгож байгуулна. Хяналтын хорооны даргыг гишүүд дотроосоо сонгоно ...” гэж намын дүрмийн заалтууд нь өөр хоорондоо зөрчилдсөн эсэхийг “бүх шатны намын хяналтын байгууллагад тус шатны төлөөллийн төв байгууллага, гүйцэтгэх төв байгууллагын гишүүн орохыг хориглосон агуулгатай” гэж;

в/Үндсэн дүрмийн 30.5-д “Аймаг, нийслэлийн намын хороог намын Улс төрийн зөвлөлийн шийдвэрээр байгуулна” гэж заасан боловч уг намын хороог татан буулгах зохицуулалтыг тусгаагүй талаар “... тухайн этгээдийг томилсон, сонгосон эрх бүхий бүтэц нь түүнийг эргээд чөлөөлөх, огцруулах, татан буулгах эрхийг хэрэгжүүлдэг хуулийн ерөнхий зарчмын дагуу аймаг, нийслэлийн намын хороог намын Улс төрийн зөвлөлийн шийдвэрээр байгуулна ... гэж шууд ойлгож байгаа учраас ийнхүү үгчилж оруулаагүй, нөгөө талаар аймаг, нийслэлийн намын хороо нь сум, дүүргийн буюу НАШБ-ын төлөөллөөс бүрддэг тул НАШБ нь олноороо татан буугдаж аймаг, нийслэлийн намын хорооны бүтэц бүрэлдэхүүн төлөөлөлгүй болсон буюу ажиллах боломжгүй болсон нөхцөлд түүнийг татан буулгах үндэслэл зайлшгүй үүснэ. Үүнээс бусад тохиолдолд аймаг, нийслэл дэх намын хороог татан буулгах үндэслэл үүсэхгүй” гэж;

г/Үндсэн дүрмийн 38.3-т “Төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэгийг намын дансанд хүлээн авах ба намын салбар болон бүтцийн нэгжид хуваарилах асуудлыг Улс төрийн намын тухай хуульд нийцүүлэн намын Улс төрийн зөвлөл шийдвэрлэнэ. Ингэхдээ намын салбар, бүтцийн нэгжийн үйл ажиллагаа, гишүүдийн тоо, шат шатны сонгуульд оролцсон идэвх, гаргасан үр дүнг үндэслэн төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэгийг хуваарилна” гэж төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэгийг хуваарилах хувь хэмжээг тусгаагүйг “... Хувь хэмжээний тухайд Улс төрийн намын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3, 26.4-т заасан зориулалт, хувь хэмжээний хүрээнд зарцуулах тухай хуулийн зохицуулалтын дор байж, үлдсэн хэсгийг дээр дурдсан шалгуурыг үндэслэн тухайн нөхцөлд нь шалгуур үзүүлэлтээр салбар нэгжийн хэрэгцээ, шаардлагыг харьцуулан, ач холбогдол, үр дүнгээр нь хэмжиж шийдвэрлэх шаардлагатай бөгөөд энэ тохиолдолд хувь хэмжээг дүрэмдээ хатуу

тогтоох нь төрийн санхүүжилтийг үр дүнтэй зарцуулах зорилгыг хангахад саад болж болзошгүй гэж үзэж хатуу хувь тавиагүй” гэж тус тус тайлбарласнаар дээрх заалтуудыг зөрчилгүй гэж үзлээ.

2.2.Хуулийн 17 дугаар зүйлийн 17.2-т “Намын удирдах дээд байгууллага дараах асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ”, 17.2.1-д “намын дүрэм, ... батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах” гэж;

Их нам (ИХН)-ын Үндсэн дүрмийн Гуравдугаар бүлгийн 1 дүгээр зүйлийн 1.1-д “Их” намын удирдах дээд байгууллага нь намын Их хурал байна. “Их” намын Их хурлыг “Иргэний Их чуулган” ... гэж нэрлэнэ”, 2 дугаар зүйлийн 2-т “Иргэний Их чуулганы бүрэн эрх”, 2.2-т “Намын дүрэм, дүрэмд оруулсан шинэчилсэн найруулга, нэмэлт, өөрчлөлтийг батламжлах”, 3 дугаар зүйлийн 3.1-д “Иргэний Их чуулганд оролцвол зохих нийт төлөөлөгчдийн олонх нь хүрэлцэн ирснээр хурал хүчин төгөлдөр болох ба хуралд оролцогсдын олонхын саналаар Иргэний Их чуулганы тогтоол хүчин төгөлдөр болно” гэж тус тус заажээ.

Өргөдөл, түүнд хавсаргасан баримтууд, тухайлбал, намын ээлжит бус Иргэний Их чуулганы хуралдааны тэмдэглэл болон тогтоолууд, мөн Тооллогын комиссын 01 дүгээр тэмдэглэл, 03 дугаар тогтоол, тус намаас ирүүлсэн тайлбар зэргээс үзэхэд, Их нам (ИХН)-ын 2025 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн ээлжит бус Иргэний Их чуулганд оролцсон 239 төлөөлөгчийн 100 хувийн саналаар дэмжиж, 08 дугаар тогтоолоор намын Үндсэн дүрэм (шинэчилсэн найруулга)-ийг баталсан нь хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1, Үндсэн дүрмийн Гуравдугаар бүлгийн 2.2-т заасантай нийцсэн байна.

Иймээс Их нам (ИХН)-ын Үндсэн дүрэм (шинэчилсэн найруулга) нь бүхэлдээ Улс төрийн намын тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан намын дүрэмд тавигдах нийтлэг шаардлага болон намын дүрмээр тусгайлан зохицуулах асуудлыг тусгасан, бүртгэхгүй байх хэмжээний ноцтой зөрчил байхгүй тул бүртгэж шийдвэрлэв.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.8, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэгт заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:1.Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийн 15 дугаар зүйлийн 15.5 дахь заалтыг баримтлан Их нам (ИХН)-ын Үндсэн дүрэм (шинэчилсэн найруулга)-ийг бүртгэсүгэй.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ,
ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

Д.ГАНЗОРИГ

ИЛТГЭГЧ ШҮҮГЧ

Ц.ЦОГТ